АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийг тоймлох нь

Д.Оюунсүрэн[1], Б.Баясгаланмөнх[1], О.Отгонтогоо[1], П.Нямсүрэн[1], Б.Мэндхүү[1]

[1]АШУҮИС, Дархан-Уул аймаг дахь АУС
Цахим шуудан: Oyunsuren.dn@mnums.edu.mn, Утас: 99642217

Түлхүүр үг:

Сувилагчийн Техник Мэргэжлийн Сургууль
Сувилагчийн сургууль
АУДуС
АУК
АУС

Товч утга: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийг үечлэн тоймлох зорилготойгоор түүхийн баримт судлал, он цагийн баримтат эх сурвалж, сургуулийн архивын материалд тулгуулан судалгааг хийсэн. **Үр дүн:** Сургуулийн түүхийн бүтэц, зохион байгуулалтын үечлэл: I үе шат Сувилагчийн Техник Мэргэжлийн Сургууль (1969-1972), II үе шат Сувилагчийн сургууль (1972-1978), III үе шат Анагаах Ухааны Дунд Сургууль (1978-1997), IV үе шат Анагаах Ухааны Их Сургуулийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллеж (1997-2010), ЭМШУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж, V үе шат буюу ЭМШУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль (2010-2014), VI үе шат АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль 2014 оноос өнөөдрийг хүртэл 6 үе шатыг дамжин хөгжиж, Монгол улсдаа “Дарханы Анагаах” нэрээ дуурсгасан сургуулийн Алсын хараа, Эрхэм зорилгодоо хүрэх, үнэт зүйлээ тодорхойлсон, ард олондоо нэр хүндтэй, үе, үеийн олон зуун эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн гаргасан, уламжлал-шинэчлэлийг хослуулсан нээлттэй сургууль, эрдмийн уурхай АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль гэж дүгнэж байна.

Үндэслэл: Монгол улсад “Дарханы Анагаах” нэрээр алдаршсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль (АШУҮИС)-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль (АУС) нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Сайд Нарын Зөвлөлийн (СНЗ)1967 оны 203-р тогтоолоор 1969 онд “Сувилагчийн техник мэргэжлийн сургууль” нэртэй байгуулагдсанаас хойш 53 жилийн түүхийг бүтээжээ. Тус сургууль нь АШУҮИС-ийн “Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох” алсын хараан дор “Дэлхийн жишигт нийцсэн чадварлаг мэргэжилтэнг бид бэлтгэнэ”, “Олон Улсын стандартад нийцсэн, чанартай боловсрол, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг нээлттэй сургууль байхад оршино” гэсэн эрхэм зорилгыг тавин ажиллаж байна.

Оюутан сурагчдыг нийгэмшүүлж, бусдын эрх чөлөөг хүндэтгэдэг, сурах хариуцлагаа бүрэн ухамсарласан, мэргэжилдээ дур сонирхолтой, бусдад чин сэтгэлээсээ туслах хүсэл эрмэлзлэлтэй Анагаах ухааны тусгай дунд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх нь тус сургуулийн Монгол улсын эрүүл мэнд, анагаах ухааны хөгжилд оруулж байгаа хувь нэмэр юм. Иймээс өнөөдрийн оюутан, маргаашийн мэргэжилтэнг өндөр чадвартай, зөв хандлагатай хүн болгон төлөвшүүлэхэд “Сайн санаа, Сайхан сэтгэл” буюу “4 сайн” хөтөлбөр нь оюутан суралцагсдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, сургууль хамт олны үнэт зүйл, сургуулийн соёл болон хөгжиж байна.

2014 онд Анагаахын суурь боловсрол олгох хөтөлбөрөөр “Хүний их эмч” бэлтгэх сургалтыг эхлүүлсэн. “Багшийн хөгжил 2016-2024” хөтөлбөрийн хүрээнд эрдэмтэн судлаач багш нарын тоо нэмэгдэж байна. 2014 онд “Сайхан сэтгэл” эмнэлгийг нээн ажиллуулж эхэлсэн нь Дархан-Уул аймгийн ард иргэд, оюутан залууст эрүүл мэндийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг бий болгосноор сургуулийн эрхэм зорилгын хүрээнд инновацид суурилсан боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээг үзүүлэхэд чиглэгдэж байна. Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, үе үеийн ахмадууд, төгсөгчид, шавь нар, зорилго нэгт хамт олноороо бахархан хойч үеийнхэндээ зориулан, он цагийн

дараалал, түүхэн хөгжлийн үечлэлийн баримтат эх сурвалжид үндэслэн эмхэтгэж, энэхүү судалгааг хийсэн болно.

Зорилго: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийг үечлэн тоймлох

Арга, аргачлал: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхийн баримт судлал, "Цахим музей" CD бичлэг, Сургуулийн он цагийн баримтат эх сурвалж, Сургуулийн архивын материалуудыг ашиглан судалгааг хийсэн.

Үр дүн:

Сургуулийн түүхийн бүтэц, зохион байгуулалтын үечлэл:

1-р үе шат буюу 1969-1972 он. Сувилагчийн Техник Мэргэжлийн Сургууль: Сургуулийн анхдагчууд: 1969 он "Сувилагчийн техник мэргэжлийн сургууль" нь 2 багш, 52 сурагчтай, анх байгуулагдаж, анхны захирлаар хүний их эмч Эрхэмбаярын Мишгээ, анхны багш нараар Э.Мишгээ, Г.Жамбалжав, анхны ажилчдаар нярав Юра, үйлчлэгч Л. Ааяахүү нар ажиллажээ. Сургууль одоогийн Дархан-Уул аймгийн 16-р сургуулийн суурин дээр Монгол цэргийн эмнэлэг байсан цагаан байшинд үйл ажиллагаагаа эхлүүлж, анхны номын сан 500 гаруй номын фондтой ажиллаж эхэлсэн байна.

2-р үе шат буюу 1972-1978 он Сувилагчийн сургууль: Бүтэц, зохион байгуулалт БНМАУ-ын СНЗ-ийн 1970 оны 176-р тогтоолоор "Сувилагчийн сургууль" болж, захирлаар (1972-1985 он) хүний их эмч Түдэвийн Хорхой, Хичээлийн эрхлэгчээр Г.Жамбалжав нар ажилласан. Сургуулийг хуучин Дарханаас одоогийн нэгдсэн эмнэлгийн подваль 4 том өрөөнд нүүлгэн шилжүүлж, орон сууцны (одоогийн 13-р баг, 24-р байрны 5 давхарт) 3 өрөөнд дотуур байрыг ажиллуулав. Анхны Үйлдвэрчний эвлэлийн хороо байгуулагдаж, даргаар нь Ч.Бямбадорж ажиллав. 1974 онд 280 оюутны суудал, 1692.4 м/кв ашигтай бүхий 2 давхар хичээлийн байр (Б байр) ашиглалтанд оров.

3-р үе шат буюу 1978-1997 он Анагаах Ухааны Дунд Сургууль: Бүтэц, зохион байгуулалт: БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1978 оны 2 сарын 03-ны 26-р тогтоолоор "Анагаах Ухааны Дунд Сургууль" болж, Т.Хорхой, Т.Баатар, П.Хайдав нар захирлаар, Т.Багаа нь захирлын үүрэг гүйцэтгэгчээр, хичээлийн эрхлэгчээр Г.Жамбалжав, Д.Лхамжав, С.Бямбажав, Я.Жаалхүү, Т.Бадмаа, Л.Хашхүү, Н.Цэцэгнавч нар ажилласан. 1983.12.28-ны өдөр 2483.8 м/кв ашигтай талбай бүхий, 4 давхар, 300 оюутны дотуур байр ашиглалтад оров. Сургуулийн номын сан өргөжиж 70 гаруй суудалтай уншлагын танхим, 2 номын санч, 13100 гаруй номын фондтой болов. 1994 онд Боловсролын болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар АУИС-ийг түшиглүүлэн Дархан хотын АУДуС-ийг Анагаах ухааны дээд ба дунд боловсрол олгох коллеж болгох бүтцийг батлав. 1995 онд бүтцэд өөрчлөлт орж, Сургалтын албаны бүтэц батлагдсанаар өнөөгийн Сургалтын Бодлого Зохицуулалтын Албаны суурь тавигдав. 1996 онд захирлын дэргэдэх зөвлөл 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдав. Дархан хотын Анагаах Ухааны Дунд Сургуульд 1993-1994 оны хичээлийн шинэ жилд Уламжлалт Анагаах Ухааны шинэ анги нээгдснээр Монгол улсад анхны уламжлалт анагаах ухааны дунд мэргэжилтэн бэлтгэх суурь тавигдсан. Уламжлалт Анагаах Ухааны анги нээхэд сургуулийн захирал П.Хайдав, анхдагчаар багш Ч. Минжмаа, Д.Төрбат, Б. Батчулуун, Б.Мөнх-Эрдэнэ, Д.Тунгалагтамир, Д.Оюун, Д.Төрбат, Ч. Минжмаа, Я.Жаалхүү, Батбаатар, Б.Балдансамбуу, Ж.Саранчимэг нар ажиллаж байв. 2012 оны байдлаар 231 бакалавр боловсролтой сувилагч, 536 уламжлалт сувилахуйн бага эмчийг бэлтгэж төгсгөжээ.

4-р үе шат буюу 1997-2010 он. Анагаах Ухааны Их Сургуулийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллеж, ЭМШУИС-ийн харъяа Анагаах Ухааны Коллеж: Бүтэц, зохион байгуулалт: Гэгээрлийн яам, ЭМНХЯ-ны (Эрүүл Мэнд Нийгмийн Хамгаалалын Яам)-ны сайдын хамтарсан А/76 тоот тушаалаар 1997 оноос АУИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллеж болон зохион байгуулагдаж, сургуулийн түүхийн нэгэн шинэ үе болох дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. Тус онуудад П.Хайдав, М.Нямсүрэн нар захирлаар, Д.Алтанхүү, М.Нямсүрэн, Р.Октябрь нар хичээлийн эрхлэгч, дэд захирлаар ажилласан. Тус сургууль нь коллеж болсноор Сувилгаа, Суурь мэргэжлийн тэнхим, Нийгмийн эрүүл мэнд, Мэргэшүүлэх тэнхим, Эх-барих, хүүхдийн тэнхим, Монголын уламжлалт эмчилгээний тэнхим гэсэн тэнхимийн зохион байгуулалтад шилжсэн ба Сургалт хариуцсан дэд захирлаар Р.Октябрь ажилласан байна. АУК-ийн Удирдах зөвлөлийг АУИС-ийн захирлын 2000 оны 09-р сарын 22-ны өдрийн 474 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй, 2001 онд захирлын зөвлөл, сургалт арга зүйн зөвлөл, эрдэм шинжилгээний ажлын зөвлөл тус тус байгуулагдав. 2001онд Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэлийг анх удаа, 2007 онд 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн сургууль болсон.

5-р үе шат буюу 2010-2014 он ЭМШУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль: Монгол Улсын Засгийн Газрын 15-р тогтоолоор 2010 оны 07-р сарын 01-нээс ЭМШУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Салбар Анагаах Ухааны Сургууль болов. Тус онуудад М.Нямсүрэн, Д.Зоригтбаатар нар захирлаар, СА-ны даргаар Р.Октябрь, Ш.Шатар, Б.Баясгаланмөнх нар 4 алба, 6 тэнхмийн бүтэцтэй ажиллажээ. 2011 онд Оюутны эрдэм шинжилгээний бүтээлийг шалгаруулах комисс, "Багшийн ажлын ачааллыг тогтоох, гүйцэтгэлийг тооцох журам"-ыг шинэчлэн батлав. 2012 оноос бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөн, 5 алба, 7 тэнхим, Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн 13 хүн, Эрдмийн зөвлөл 8 хүнтэй ажилласан байна. 2012 онд 3 давхар хичээлийн шинэ байр (А байр) ашиглалтад орж, сургалтын анги танхим, лаборатори, цайны газар, номын сан зэргийн орчин нөхцөл сайжирч, судлаач багш, оюутнуудад зориулсан "Liberal Art Research Library" номын санг ажиллуулав. 2012-2015 онд хэрэгжүүлэх "Багшийн хөгжил-2015" хөтөлбөрийг боловсруулав.

6-р үе шат буюу 2014 оноос АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль: Бүтэц, зохион байгуулалт: Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24-р зүйлийн 24.2 дахь хэсэг, ЭМШУИС-ийн 2014 оны 005-р тогтоолыг үндэслэн, Боловсролын сайдын 2014 оны 04-р сарын 09-ны өдрийн А/134 тоот тушаалаар Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль болов. Д.Зоригтбаатар, Б.Баясгаланмөнх (одоог хүртэл) нар захирлаар, П.Нямсүрэн, О.Отгонтогоо нар захирлын үүрэг гүйцэтгэгч, Б.Баясгаланмөнх, П.Нямсүрэн, Б.Хандаа (одоог хүртэл) нар Сургалтын Бодлого Зохицуулалтын Албаны даргаар ажилласан. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ЭХ/14/07/ 02 тоот гэрчилгээгээр дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх “Сайхан сэтгэл” эмнэлгийг байгуулж, эмнэлгийн даргаар Ө.Сарангэрэл ажиллав. 2016 онд “Багшийн хөгжил 2016-2024” хөтөлбөрийг боловсруулав. Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны (ҮЭХ) тэргүүлэгчдийг .шинээр сонгож, сургуулийн захиргаа болон ҮЭХороо хоорондын “Хамтын гэрээ” /9 зүйл, 82 заалт, 123 хэсэгтэй/ -г байгуулав. Бүтэц, зохион байгуулалт: Захирлын зөвлөл ба чанарын удирдлагын хороо, Редакцийн зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулав. Хөтөлбөрийн дэд хороог байгуулав. Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, сургуулийн эрх зүйн баримт бичиг, үйл явцын зураглал, хэрэгжилт, сайжруулалт хийгдэв. Оюутнууд Unimis Cloud University 1.0 системийн ашиглан, Сургуулийн захиргаа, ҮЭХорооны “Хамтын гэрээ”-г шинэчлэв. “Төгсөгчдийн холбоо” төрийн бус байгууллага байгуулагдав. Төгсөгчдөөс мөшгих судалгаа, ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч эхлэв. 2018 онд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн удирдах зөвлөлийн 2018.6.20 өдрийн 28 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэв. 2018.09.18 А/121 захирлын тушаалаар сувилахуйн эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулав.

Боловсруулан мөрдөж буй баримт, бичиг, дүрэм, журам: Хөгжлийн стратеги төлөвлөгөө 2018-2024 он, Хүний нөөцийн хөгжлийн бодлого 2018-2024 он, Багшийн хөгжил 2016-2024 он, Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, оюутны элсэлтийн журам, ёс зүйн хорооны ажиллах журам, тендер, худалдан авалтын үйл ажиллагааг зохицуулах журам, Эмнэлзүйн ур чадварын төвд ажиллах журам, Төгсөлтийн дараахь сургалт зохион байгуулах журам гэсэн журмуудыг хэрэгжүүлэн ажиллахын зэрэгцээ тухайн цаг үеийн байдалд нийцүүлэн ажиллаж байна. Англи хэлний IELTS шалгалтын “ИЭСПИ сан”-тай гэрээ байгуулж, IELTS-ийн шалгалтыг Дархан-Уул аймагт зохион байгуулахад хамтран ажиллах салбар болов. АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС-ийн “Төгсөгчдийн холбоо”-ны салбаруудыг Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Архангай аймгуудад байгуулав. Хичээлийн А байранд 2019 онд 32200 гаруй номын фондтой ЭКО номын сан ашиглалтад оров. 2022 онд тус сургууль нь 6 алба (Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба, Сургалтын алба, Оюутны алба, Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба, Эмнэлгийн хөгжлийн алба, Санхүүгийн алба)-ны шинэ бүтэц, албан ёсны эрдэмтдийн зөвлөлийг байгуулан, үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.

Хэлцэмж:

1. Н.Даваацэрэн, Ц.Лхагвасүрэн Э.Доржпагма нарын эммхэтгэсэн “Бид хамтдаа-70 жил” Зургийн цомог бүтээлд хамт олны зураг, 2011 он
2. хүртэлх АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийн 5 үе шатыг үечлэн харуулсан бол бидний судалгаа 6 дахь үе шатыг харуулснаар түүхэн хөгжлийн үргэлжлэл болж байна.
3. Дарханы Анагаах-50 жил - Түүхэн товчоон (1969-2019) АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн түүхэн хөгжлийн 6 үе шатыг үечлэн гаргасан нь энэхүү өгүүллийн суурь үндэс боллоо.
4. Дархан хотын Анагаах Ухааны Дунд Сургуульд 1993-1994 оны хичээлийн Шинэ жилд Уламжлалт Анагаах Ухааны эмнэлэгийн салбар болж шинэ анги нээгдсэн ба захирал Хайдав нээж, АХГЗ-ын дарга Д.Цэвээнжав, Оточ эмнэлэгийн эмч П.Сагараажав, Хятад Улсын Жони мужийн эмч, дэд эрдэмтэн Эрдэмт, төвд хэлний мэргэжилтэн Бүрэнбаяр, Монгол УЭ-ийн эмч Батбаатар нар оролцсон нь тус сургууль Хятад Улсын Уламжлалт Эмнэлэгтэй хамтран ажиллах эхлэл 30 гаруй жил боллоо гэж үзэж байна.

Дүгнэлт: АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль нь түүхэн хөгжлийн явцад “Сувилагчийн техник мэргэжлийн сургууль”-иас “АШУҮИС-ийн салбар сургууль болтлоо **6 үе** шатыг дамжин хөгжиж, Монгол улсдаа “Дарханы Анагаах” нэрээ дуурсгасан сургуулийн Алсын хараа, Эрхэм зорилгодоо хүрэх, үнэт зүйлээ тодорхойлсон, түмэн олондоо нэр хүндтэй, үе, үеийн олон зуун эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн гаргасан, уламжлал-шинэчлэлийг хослуулсан нээлттэй сургууль, эрдмийн уурхай юм.

Ном зүй:

1. *АУИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллежийн өөрийн үнэлгээний тайлан. Дархан-Уул аймаг 2001; х. 7, 25.*
2. *АШУҮИС-ийн Дархан -Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль, 45 жил Түүхэн товчоон (1969-2014). Мөнхийн Үсэг ХХК Дархан салбар. Дархан-Уул аймаг 2014; х.18, 32.*
3. *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн Магадлан итгэмжлэлийн ахиц дэвшлийн тайлан. Дархан-Уул аймаг 2018; х.3, 10, 13.*
4. *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн архив. 1982-2019; х.5, 15, 29.*
5. *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль 50 Түүхэн товчоон 1969-2019. Дархан-Уул аймаг 2019; х. 8, 21, 50, 77, 91.*
6. *АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль, Дарханы Анагаахын бахархал Эргэн дурсахуй-50. Дархан-Уул аймаг 2019; х.3*
7. *Бүрхантын мэлмий сонин Дархан хотын сонин 1993. 10. 20-*

ний өдрийн № 64
8. Даваацэрэн Н, Лхагвасүрэн Ц, Доржпагма Э нарын эмхэтгэсэн "Бид хамтдаа-70 жил" ЭМШУИС-ийн 70 жилийн ойд зориулсан Зургийн цомог бүтээл.х. 388 -394.
9. Дархан-Уул аймгийн архив, 1969-2000; х.1,3,8.
10. Менежерийн үр дүнгийн гэрээний тайлан (2016, 2017, 2018, 2019, 2020, 2021)
11. ЭМШУИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллежийн хоёр дахь удаагийн Магадлан итгэмжлэлийн ахиц дэвшлийн тайлан. Дархан-Уул аймаг 2007; х.3,15,21.
12. ЭМШУИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллеж. Дурсамж дүүрэн-40 жил. Дархан-Уул аймаг 2009; х.1.

An overview of the historical development of the School of Medicine in Darkhan-Uul aimag

Oyunsuren D[1], Bayasgalanmunkh B[1], Otgontogoo O[1], Nyamsuren P[1], Mendkhuu B[1]

[1]School of Medicine in Darkhan-Uul aimag, MNUMS
E-mail: Oyunsuren.dn@mnums.edu.mn, Tel: 99642217

In order to periodically review the historical development of the National University of Medical Science Mongolia in Darkhan-Uul province, the research was conducted based on historical facts, chronological documents and school archives.

Results: History pages: The first stage-1969-1972 Vocational training school of nursing, The second stage-1972-1978 Nursing school, The third stage-1978-1997 Medical school, The fourth stage-1997-2010 Darkhan medical College, The fifth stage-2010- 2012 Darkhan branch school of Health Sciences University, The sixth stage-2014 – until now National University of Medical Sciences Mongolia, Darkhan Medical School.

This school has been developing through 6 stages since 2014. The Darkhan Medical School in Mongolia is considered to be an open school and research mine that combines tradition and innovation to achieve its vision, mission, values, and has trained hundreds of reputable medical professionals.

Keywords: Nursing Technical School, School of Nursing